



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2021 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

**“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-нд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.11, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.4.5, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалт болон Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2017 оны А/42 тоот тушаалын хавсралтаар баталсан “Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журам”-ыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны 58 дугаар тогтоолоор баталсан “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-нд дор дурдсан агуулгатай Хүснэгт №6-г нэмсүгэй.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ

Хүснэгт №6

№	Тусгай зөвшөөрлийн төрлүүд	Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ /мян.төг/		
		Монгол Улсын нутаг дэвсгэрт	Улаанбаатарт	Аймаг*
1. Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ				
1.1	Радио, телевизийн газрын сүлжээ	5 000.0	3 000.0	1 000.0
2. Радио, телевизийн үйлчилгээ				
2.1	Олон нийтийн телевиз	3 000.0		
2.2	Олон нийтийн радио	1 500.0		
2.3	Өргөн нэвтрүүлгийн телевиз	6 000.0	3 000.0	800.0
2.4	Өргөн нэвтрүүлгийн радио	2 500.0	800.0	200.0
2.5	Арилжааны телевиз	4 500.0	2 500.0	600.0
2.6	Арилжааны радио	2 500.0	800.0	200.0
2.7	Төлбөртэй телевиз	5 000.0		
2.8	Төлбөртэй радио	2 500.0		
2.9	Өргөн нэвтрүүлгийн телевиз (Хиймэл дагуулын сүлжээгээр)	-	-	3 000.0

2.10	Арилжааны телевиз (Хиймэл дагуулын сүлжээгээр)	-	3 500.0	3 000.0
3. Олон суваг дамжуулах үйлчилгээ				
3.1	Утастай, утасгүй сүлжээгээр	8 000.0	3 500.0	800.0
3.2	Хиймэл дагуулын сүлжээгээр	15 000.0		

* Улаанбаатар хотод болон 10-аас дээш аймагт үйлчилгээ эрхэлж байвал зохицуулалтын үйлчилгээний хөлсийг улсын нутаг дэвсгэрт гэсэн төлбөрөөр тооцно.

- Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны 58 дугаар тогтоолоор баталсан “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-ний Хүснэгт №1-ын 1.2-ыг, Хүснэгт №2-ын 2.1, 2.2, 2.3, 3.1, 3.2, 3.3, 3.4-ыг тус тус хассугай.
- Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны 58 дугаар тогтоолоор баталсан “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-ний Хүснэгт №2-ын “4. Шуудангийн үйлчилгээ”, “4.1 Үндсэн”, “4.2 Ложистик”, “4.3 Буухиа”, “4.4 Улс хоорондын шуудангийн илгээлт”, “4.5 Шуудангийн захиалгат хүргэлтийн үйлчилгээ” гэснийг “2. Шуудангийн үйлчилгээ”, “2.1 Үндсэн”, “2.2 Ложистик”, “2.3 Буухиа”, “2.4 Улс хоорондын шуудангийн илгээлт”, “2.5 Шуудангийн захиалгат хүргэлтийн үйлчилгээ” гэж, “5. Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт засвар үйлчилгээ”, “5.1 Гадна холбооны кабель шугамын угсралт”, “5.2 Цамхаг, түүн дээрхи холбооны тоног төхөөрөмж угсралт” гэснийг “5. Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт засвар үйлчилгээ”, “3.1 Гадна холбооны кабель шугамын угсралт”, “3.2 Цамхаг, түүн дээрхи холбооны тоног төхөөрөмж угсралт” гэж тус тус өөрчилсүгэй.
- Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан 2019 оны 44 дугаар тогтоол, 2021 оны 14 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.
- Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг /-т үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Т.НАРАНМАНДАХ